



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 436

Улаанбаатар хот


“Хувийн хөрөнгө оруулалтын сангийн
үйл ажиллагааны тухай журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.12, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9.2, 55.1.2, 55.1.4, 43.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000470

ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хувийн хөрөнгө оруулалтын сангийн удирдлага, түүний бүтэц зохион байгуулалт, сангийн хөрөнгө ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон санг нэгтгэх, нийлүүлэх, татан буулгахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд Иргэний хууль, Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Мөнгө угаах терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журам болон Хорооноос тогтоосон бусад дүрэм, журмыг мөрдөнө.

1.3. Энэхүү журамд “гүйцэтгэх удирдлага” гэснийг тухайн хөрөнгө оруулалтын санг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын менежментийн компанийн сангийн менежерийг ойлгоно.

1.4. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь үйл ажиллагаандаа Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 13.1-д заасан зарчмыг удирдлага болгон ажиллана.

1.5. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бол Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийг дагаж мөрдөнө.

Хоёр. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал

2.1. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн эрх барих дээд байгууллага нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал байх бөгөөд уг хуралд тухайн сангийн нэгж эрх эзэмшигч иргэн, хуулийн этгээд оролцох эрхтэй байна.

2.2. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд нэг нэгж эрх тус бүр нэг саналын эрхтэй байх ба нэгж эрх эзэмшигч иргэн, хуулийн этгээд тус бүрийн саналын эрх нь тэдгээрийн тус бүрийн эзэмшил дэх нэгж эрхийн тоогоор тодорхойлогдоно.

2.3. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл нэг адил хамаарах ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бусад бүрэн эрхийг сангийн дүрмээр тодорхойлно.

2.4. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд нэгж эрх эзэмшигчдийн хурлын дараах бүрэн эрхийг заавал тусгана:

2.4.1. менежментийн компанийг сонгох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах шийдвэр гаргах;

2.4.2. кастодианыг сонгох, хөрөнгө хадгалах гэрээ байгуулах шийдвэр гаргах;

2.4.3. төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар бол гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

2.4.4. менежментийн компани болон кастодианы төлбөр, урамшууллын дээд хязгаарыг тогтоох.

2.5. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээний хуваарийг тухайн сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас батлах ба гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээг уг хуваарьт сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрээр гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээгээр тогтооно.

2.6. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, шийдвэр гаргахтай холбоотой харилцаанд Компанийн тухай хуулийн холбогдох заалт нэг адил үйлчилнэ.

2.7. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 59.4-д заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй тохиолдолд тухайн сангийн төлөөлөн удирдах зөвлөл эсхүл гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болсонд тооцох ба тэдгээрийн байгуулсан аливаа гэрээ, хэлцэл нь хүчин төгөлдөр бус болно.

2.8. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахаас өмнө сангийн нэгж эрх эзэмшигчдийн зүгээс дараах баримт бичигтэй танилцуулах боломжийг менежментийн компани бүрдүүлэх үүрэгтэй:

2.8.1. хувийн хөрөнгө оруулалтын сангийн жилийн тайлан;

2.8.2. санхүүгийн жилийн тайлангийн аудитын байгууллагын дүгнэлт;

2.8.3. кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;

2.8.4. менежментийн компанийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан;

2.8.5. хувийн хөрөнгө оруулалтын сангийн урсгал зардал, цалин, урамшуулал;

2.8.6. хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан бусад.

2.9. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч нь гүйцэтгэх удирдлагад ээлжит бус хурал хуралдуулах хүсэлтийг хэдийд ч тавьж болох бөгөөд тухайн хуралд хэлэлцэх асуудал, хурал болох өдөр, цаг зэргийг хүсэлтэд тусгасан байна.

2.10. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдсон зардлыг тухайн сан бүрэн хариуцана.

2.11. Дараах тохиолдолд хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг заавал зарлан хуралдуулна:

2.11.1. хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны явцад хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн хэмжээ нь дараалсан 10 хоногийн туршид буурсан, тухайн сан үйл ажиллагаагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40 болон түүнээс дээш хувиар буурсан;

2.11.2. хөрөнгө оруулалтын менежментийн компани татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас шинээр хөрөнгө оруулалтын менежментийн компанид хөрөнгө итгэмжлэн удирдах эрхийг шилжүүлэх шаардлага үүссэн;

2.11.3. кастодиан татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас шинээр хөрөнгө хадгалах гэрээний эрхийг өөр кастодианд шилжүүлэх шаардлага үүссэн;

2.11.4. хөрөнгө оруулалтын менежментийн компанийг сонгох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний эрхийг шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах;

2.11.5. кастодианыг сонгох, хөрөнгө хадгалах гэрээний эрхийг шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах;

2.11.6. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн дотоод хяналтын албанаас хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;

2.11.7. дүрэмд заасан бусад тохиолдолд.

2.12. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлага нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай санал, шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хурлыг хуралдуулах шийдвэрийг гаргах ба тухайн нөхцөл байдалд нийцүүлэн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хамгаалах шаардлагатай арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

2.13. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал болох өдрөөс 14 ба түүнээс дээш хоногийн өмнө хурал зохион байгуулагч этгээд нь хурлын тов болон холбогдох мэдээллийг бичгээр болон цахим шуудангаар хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдэд хүргүүлнэ.

2.14. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нийт гаргасан нэгж эрхийн 50 хувиас дээш хувийг эзэмшигч хуралд оролцсоноор хурлын ирц бүрдсэн гэж үзэж тухайн хурал хүчин төгөлдөр болно.

2.15. Энэхүү журмын 2.14-д заасан ирц бүрдээгүй бол хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг товлон. Хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглох бөгөөд хурлыг дахин хуралдуулахтай холбоотой харилцааг сангийн дүрмээр тодорхойлно.

2.16. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зохион байгуулагч нь бүх нэгж эрх эзэмшигчдэд хурлын үйл явцыг хүртээмжтэй байдлаар зохион байгуулах ба дараах нөхцөл боломжоор заавал хангасан байна:

2.16.1. саналын эрх хэрэгжүүлэх;

2.16.2. асуулт асуух, хариулт авах;

2.16.3. итгэмжлэлийн үндсэн дээр санал өгөх;

2.16.4. хурлын явцын талаар тэмдэглэл хөтлөх;

2.17. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралтай холбоотой бусад харилцааг Компаний тухай хууль болон сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас тогтоосон дүрэм, журмаар нарийвчлан зохицуулна.

2.18. Хувийн хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлж байгаа менежментийн компанийн зүгээс тухайн санд томилон ажиллуулж байгаа менежер, ажилтан болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь өөрийн өмчлөл дэх нэгж эрх эзэмшигчийн хувиар хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд саналын эрх эдлэхгүй. Энэхүү заалт нь итгэмжлэгдсэн этгээдийн хувиар бусдыг төлөөлөн гишүүдийн хуралд оролцох, саналын эрх эдлэхэд хамаарахгүй.

Гурав. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

3.1. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн активт Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1-т заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэл хамаарна.

3.2. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн цэвэр активын үнэлгээг Хорооноос тогтоосон “хөрөнгө оруулалтын сангийн цэвэр активыг тооцоолох журам”-ын дагуу тооцоолно.

3.3. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуулиар зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгслийг тухайн хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүнд оруулахгүй байхаар шийдвэрлэж болно.

3.4. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь санхүүгийн хөшүүрэг хэрэглэсэн, эсхүл үнэт цаасны үнийн бууралтаас ашиг хүртэх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын хэрэгслийг активын бүтэцдээ оруулж болно.

3.5. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 25.1.11-д заасан журмын дагуу хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг барьцаалан зээл авч болно.

3.6. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь дүрэмд өөрөөр заагаагүй бол бусдад мөнгөн хэлбэрээр зээл олгохыг хориглоно. Үүнд өрийн хэрэгсэлд оруулах хөрөнгө оруулалт хамаарахгүй.

3.7. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн активыг бүрдүүлж байгаа хөрөнгийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тухайн санд үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани болон нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгөөс тусдаа, тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэр дээрх нээсэн дансанд байршуулах бөгөөд уг хөрөнгийн нягтлан бодох бүртгэл нь салангид, бие даасан байна.

3.8. Энэхүү журмын 3.7-д заасан хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөс хөрөнгө оруулалтын менежментийн компани, менежерийн бусдын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангахгүй.

3.9. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн менежер нь гэрээнд зааснаас гадна тухайн сангийн хөрөнгөтэй холбоотой дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.9.1. сангийн хөрөнгө нь тухайн сангийн дүрэмд тусгасан болон Хорооноос тогтоосон нөхцөл шаардлагад хүрч байгаа талаар байнгын хяналтыг хэрэгжүүлж ажиллах;

3.9.2. кастодианы үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэх гэрээнийн эрхийн хүрээнд хяналт тавих;

3.9.3. кастодианыг өөрчлөх, өөр кастодианд хөрөнгийг хадгалах тухай шийдвэр гарч уг эрхийг олгох тохиолдолд уг ажиллагааг эрсдэлгүй зохион байгуулах, шаардлагатай зөвлөмж, удирдлагаар хангах;

3.9.4. хувийн хөрөнгө оруулалтын сантай холбоотой хөрөнгийн бүхий л гүйлгээнд хяналт тавих, эрсдэлийг тооцох;

3.9.5. хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой санхүүгийн анхан шатны бүх баримтыг үйлдсэн болон хүлээн авсан даруйдаа хувийг нь мэргэшсэн нягтлан бодогч болон кастодианд хүргүүлэх;

3.9.6. тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, байгуулсан гэрээнд зааснаас илүү хэмжээний, эсхүл тэдгээрт заагдаагүй зардал, төлбөрийг сангийн хөрөнгөөр гүйцэтгэхгүй байх;

3.9.7. хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журамд заасны дагуу нэгж эрх эзэмшигчдийг шийдвэр гаргахад хангалттай мэдээллээр хангаж ажиллах;

3.9.8. энэхүү журам болон Хорооноос тогтоосон бусад шаардлагыг мөрдөн ажиллах.

3.10. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн активын үнэлгээчин, эсхүл үнэлгээ хийх эрх бүхий хуулийн этгээд нь хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, аудитын компани, түүний ажилтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд байхыг хориглоно.

3.11. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн бүртгэлийг сангийн менежер болон эрх бүхий кастодиан хөтлөн явуулж уг ажиллагааны гүйцэтгэлийн талаар үйл ажиллагааны тайланд тусгана.

3.12. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн менежер нь сангийн хөрөнгийг сангийн дүрэмд зааснаас бусад зориулалтаар ашигласан үйлдэл нь сангийн актив болон хөрөнгийн бүтцэд хамаарах хөрөнгөд хохирол учруулсан нь тогтоогдсон бол уг хохирлыг сангийн менежер өөрийн хөрөнгөөр барагдуулна.

3.13. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол сангийн хөрөнгө нь хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компани, кастодиан болон тухайн сангийн удирдлагын буруутай үйл ажиллагаанаас хамааралгүйгээр буюу нийгэм, эдийн засаг, хууль, эрх зүй болон зах зээлийн хүчин зүйлсээс хамаарч бууран хохирол учирсан бол уг хохиролыг сангийн хөрөнгөөр барагдуулна.

3.14. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн орлого, зарлагыг тооцоолох, ашгийг тодорхойлох, төлбөр тооцоо, цалин урамшууллыг тооцох, олгох гэх зэрэг санхүү, нягтлан бодох бүртгэлийг Хорооны “Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх заавар” болон холбогдох нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу гүйцэтгэнэ.

3.15. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчид тухайн санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн боловсруулсан хөрөнгө итгэмжлэн удирдах журамд үндэслэн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулснаар уг хөрөнгө оруулалтын санг төлөөлөх эрх хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний томилсон менежерт үүснэ.

3.16. Өөр бусад хөрөнгө оруулалтын сангийн гаргасан нэгж эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг эзэмшихийг хориглоно (үүнд гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сан нэг адил хамаарна);

3.17. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь сангийн нэгж эрх тус бүрд оногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ нь тухайн нэгж эрхийн нэрлэсэн үнээс илүү байх нөхцөлд аливаа урамшууллыг олгож болно. Энэхүү нөхцлийг хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журам болон холбогдох гэрээнд заавал тусгана.

Дөрөв. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн тайлан

4.1. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн удирдлага нь тухайн сангийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдлын талаар нэгж эрх эзэмшигчдийг мэдээллээр хангах зорилгоор сан нь үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайлан гаргана.

4.2. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн удирдлага нь үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланг доор дурдсан хугацаанаас өмнө гаргаж Хороонд ирүүлнэ:

4.2.1. үйл ажиллагааны жилийн эцсийн тайланг тухайн санхүүгийн жил дууссаны дараа жилийн I дүгээр улирлын дотор;

4.2.3. үйл ажиллагааны хагас жилийн тайланг 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор.

4.3. Хувийн хөрөнгө оруулалтын сан, түүний удирдлага нь энэхүү журмын 4.2-т заасан үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайлан гаргах хугацаа, хуваарийг өөрчлөх эрхгүй.

4.4. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланд холбогдох хугацааны санхүүгийн тайланг бүрэн эхээр нь хавсаргана.

4.5. Энэхүү журмын 4.1-д заасан үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланд дараахь агуулгыг тусгасан байна:

4.5.1. тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэр, хөрөнгө оруулалтын зорилго, тэдгээр зорилгод хүрэх бодлого мөн эрсдэлийн товч үнэлгээ зэргийн эрсдэлийг үнэлэх олон улсын туршлагын дагуу тооцоолон тусгасан байх;

4.5.2. тухайн тайлант үеийн хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тусгасан байх;

4.5.3. хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулалтын багц (портфейл)-ын бүтэц, үнэлгээ, тэдгээр нь тайлант үеийн турш хэрхэн өөрчлөгдсөн талаар нэгж эрх эзэмшигчид дүгнэлт хийхэд шаардлагатай мэдээллийг тусгах;

4.5.4. нэгж эрх эзэмшигчдийг сангийн аливаа үйл ажиллагаа, түүний тайлангийн үеийн эцэст гарсан үр дүнд дүгнэлт хийхэд өгөхөд шаардлагатай ач холбогдол бүхий мэдээлэл;

4.5.5. энэхүү журмын 4.4-т заасан тухайн тайлант хугацаанд хамаарах санхүүгийн тайланд үндэслэн санхүүгийн нөхцөл байдлын талаарх дүгнэлт, энэхүү журмын 4.8-д заасан харьцуулсан үзүүлэлтүүд;

4.5.6. жилийн эцсийн санхүүгийн тайланд гаргасан хөндлөнгийн аудитын тайлан;

4.5.7. энэхүү журмын 4.7-д заасан тайлант хугацаанд хамаарах сангийн менежерийн үйл ажиллагааны тайлан;

4.5.8. менежментийн компанийн үйл ажиллагааны болон дотоод хяналтын үйл ажиллагааны тайлан;

4.5.9. тайлангийн үеийн зардлын харьцаа, харьцуулсан үзүүлэлтүүд;

4.5.10. кастодиан болон сангийн менежерүүдийн зүгээс тавьсан аливаа ач холбогдол бүхий асуудлын талаар тодруулга;

4.5.11. хууль, Хорооноос баталсан журам, хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журамд заасан бусад;

4.6. Энэхүү журмын 4.1, 4.2-т заасан хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланг гаргах, түгээхэд хөрөнгө оруулалтын сангийн удирдлага нь дараах шаардлагыг хангаж ажиллана:

4.6.1. ойлгомжтой, бүрэн үнэн зөв байх бөгөөд тухайн үед хамаарах мэдээллийг бүрэн тусгасан байх;

4.6.2. үндсэн хувь нь Монгол хэл дээр гаргах ба шаардлагатай бол Англи хэл дээр гаргаж болно;

4.6.3. энэхүү журмын 4.2-т заасан хугацаанаас өмнө Хороонд хүргэх.

4.7. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн менежер нь өөрийн үйл ажиллагааны тайландаа дараах мэдээллийг тусгана:

4.7.1. тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын зорилго, түүний биелэлтийн талаарх мэдээлэл, үзүүлэлтүүд;

4.7.2. тайлант хугацаанд гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны тойм, үр дүн;

4.7.3. сүүлийн тайлангаас хойш нэгж эрх эзэмшигчдийн хурлаар батлуулах шаардлагатай гарсан аливаа үндсэн өөрчлөлтийн талаар тодруулга;

4.7.4. сүүлийн тайлангаас хойш урьдчилсан мэдэгдэл шаардсан аливаа өөрчлөлтийн талаар тодруулга;

4.7.5. Нэгж эрх эзэмшигчдийг сангийн аливаа үйл ажиллагаа, түүний талаар тайлангийн үеийн эцэст гарсан үр дүнд дүгнэлт, шүүмж өгөхөд шаардлагатай ач холбогдол бүхий мэдээлэл;

4.7.6. цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, баримтлах бодлого, хүрэх үр дүнгийн талаарх мэдэгдэл;

4.8. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланд энэхүү журмын 4.5.5-д заасны дагуу сүүлийн 3 жилийн хугацааны талаар дараахь агуулга бүхий харьцуулсан хүснэгтийг тусгана:

4.8.1. жил бүр, төрөл бүрээс гаргасан нэгж эрхийн хамгийн дээд болон доод үнэ;

4.8.2. жил бүрийн нэгж эрхэд хуваарилагдсан цэвэр орлого, үүнд тухайн үед гарсан нэгж эрхийн аливаа хуваагдал, нэгдэл зэргийг оруулах;

4.8.3. жил бүрийн эцэс дэх сангийн хөрөнгийн нийт цэвэр активийн үнэлгээ;

4.8.4. тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын зорилгод орсон өөрчлөлтүүдийн талаар харьцуулалтад орсон он тус бүрийн үзүүлтэд тодруулга өгөх, орсон өөрчлөлт, үндэслэлийн талаар товч мэдээлэл өгөх.

Тав. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн мэдээлэл

5.1. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн мэдээлэх мэдээлэл нь дараахь мэдээллээс бүрдэнэ.

5.1.1. Хороонд ирүүлэх мэдээлэл;

5.1.2. хууль тогтоомжийн дагуу мэдээлэл өгөх үүрэг бүхий бусад төрийн байгууллагад өгөх мэдээлэл.

5.2. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн дотоод мэдээлэл нь дор дурдсан мэдээллээс бүрдэнэ.

5.2.1. хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд мэдээлэх мэдээлэл;

5.2.2. хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компанийн мэдээлэх мэдээлэл;

5.2.3. кастодиан, аудитор, нягтлан бодогч, үнэлгээчин, брокер, диллерийн мэдээлэл;

5.2.4. хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журамд заасан бусад мэдээлэл.

5.3. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол олон нийтийн мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр, Монгол болон Англи хэлээр нийтэд мэдээлж болно.

5.4. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн мэдээлэлд тавигдах ерөнхий шаардлага:

5.4.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 29.2-т заасны дагуу Хорооноос зөвшөөрөл авсан байх;

5.4.2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 29.1-д заасан мэдээллийг тусгасан байх;

5.4.3. илт хуурамч, буруу, зөрүүтэй мэдээлэл болон нэгж эрх эзэмшигчдийн эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээлэл тавихгүй байх;

5.4.4. сангийн менежер нь санд хөрөнгө оруулах боломжтой аливаа этгээдэд маркетингийн мэдээллийг үнэ төлбөргүй гарган өгөх, зөвлөгөө өгөх үүрэгтэй;

5.4.5. хууль тогтоомж, дүрэм журамд заасан бусад.

5.5. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн олон нийтэд мэдээлж буй мэдээллээс үүсэх аливаа хариуцлагыг сангийн менежер хариуцна.

5.6. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь Хороонд дараахь мэдээллийг мэдээлнэ.

5.6.1. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны хагас жилийн болон жилийн эцсийн тайлан;

5.6.2. хагас жилийн болон жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон тэдгээрт орсон өөрчлөлтийн талаар тухай бүрт;

5.6.3. нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл, тэдгээрийн танилцуулга;

5.6.4. нэгж эрх эзэмшигчдийн эзэмшиж байгаа нэгж эрхийн төрөл, хэмжээ;

5.6.5. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн дотоод хяналтын албанаас хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан дүгнэлт;

5.6.6. хууль тогтоомжийн дагуу мэдээлэх шаардлагатай үнэт цаастай холбоотой хийсэн хэлцэл, арилжаа, гүйлгээний талаар болон уг хэлцэлд оролцогч талуудын талаарх мэдээлэл;

5.6.7. хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журамд орсон өөрчлөлтийг тогтоосон журмын дагуу мэдээлэх;

5.6.8. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

5.7. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд дараахь мэдээллийг мэдээлнэ:

5.7.1 тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын болон жилийн тайлан;

5.7.2. менежментийн компанийн үйл ажиллагааны тайлан;

5.7.3. сангийн менежерийн эрсдэлийг тооцоолсон тооцоолол;

5.7.4. кастодианы үйл ажиллагааны тайлан, дансны хуулбар;

5.7.5. үнэлгээчин, брокер дилертэй байгуулсан гэрээ, танилцуулга;

5.7.6. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн дотоод хяналтан албанаас гаргасан дүгнэлт;

5.8. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нийтэд мэдээлэх болон дотоод мэдээлэл үнэн бодит эсэх, мэдээллээс гарч болох эрсдэлийг тухайн хөрөнгө оруулалтын сангийн менежер хүлээнэ.

Зургаа. Хувийн хөрөнгө оруулалтын санг нэгтгэх, нийлүүлэх

6.1. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх үүрэг, хариуцлагыг өөр хувийн хөрөнгө оруулалтын санд шилжүүлэхийг хөрөнгө оруулалтын санг нэгтгэх гэнэ.

6.2. Хувийн хөрөнгө оруулалтын санг нэгтгэх шийдвэрийг гаргах эрх бүхий этгээд зөвхөн хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал байх бөгөөд нийт нэгж эрх эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6.3. Хөрөнгө оруулалтын сангийн менежер нь хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар санг нэгтгэх тухай шийдвэрийн төслийг болон санг нэгтгэх гэрээг нэгдэж байгаа хөрөнгө оруулалтын сан болон нэгтгэж байгаа хөрөнгө оруулалтын сангийн тус бүрийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар оруулж шийдвэрлүүлнэ.

6.4. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгтгэх журмын төсөлд дараахь зүйлсийг оруулсан байна.

6.4.1. нэгдэж байгаа сангийн үнэт цаасыг нэгтгэж байгаа сангийн үнэт цаас болон бусад хөрөнгөд хөрвүүлэх журам;

6.4.2. кастодианы эрх шилжүүлэн авах журам;

6.4.3. хэрэв тухайн нэгдэж буй болон нэгтгэн авч буй хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах эрх бүхий этгээдийн үйл ажиллагааг нэг менежментийн компани удирдан явуулдаг бол нэгдэж байгаа хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ хүчин төгөлдөр бус болох бөгөөд нэгтгэн авч буй сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг тухайн менежментийн компанитай өөрчилж, дахин байгуулна;

6.5. Нэгдэж байгаа хувийн хөрөнгө оруулалтын сан тус бүрийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрүүдээс гарсан санг нэгтгэх журам болон, гэрээ, холбогдох баримт бичгийг сангийн менежер Хороонд хүргүүлнэ.

6.6. Хороо журмын 6.5-д заасан журам, гэрээ, холбогдох баримт бичгийг шалгаж хууль, журам зөрчөөгүй, нэгж эрх эзэмшигчдийн оруулсан хөрөнгөд хохиролгүй бол тухайн санг нэгдсэнд тооцож, нэгдэж буй сангийн тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлнэ.

6.7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын бүртгэлээс тухайн нэгдэж орсон хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэрийг, сангийн менежер хасуулж Хороонд баримт бичгийг ирүүлнэ.

6.8. Хувийн хөрөнгө оруулалтын санг нэгтгэх үйл ажиллагаатай холбоотой гарсан бүх зардлыг сан өөрийн хөрөнгөөр хариуцана.

6.9. Хоёр буюу хэд хэдэн хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон хувийн хөрөнгө оруулалтын санд шилжүүлэхийг хөрөнгө оруулалтын санг нийлүүлэх гэнэ.

6.10. Нийлж байгаа хувийн хөрөнгө оруулалтын сангийн тус бүрийн сангийн менежер нь нийлж буй хувийн хөрөнгө оруулалтын сангуудын нэгж эрх эзэмшигчдийн хурлаар дараахь зүйлсийг тус тусдаа шийдвэрлүүлнэ.

6.10.1. хувийн хөрөнгө оруулалтын санг нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийн төсөл;

6.10.2. өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг тодорхойлсон гэрээ;

6.10.3. хувийн хөрөнгө оруулалтын сангийн шинээр батлагдсан дүрэм;

6.10.4. хувийн хөрөнгө оруулалтын сан тус бүрийн хөрөнгийг шинээр бий болсон хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөд хөрвүүлэх саналыг тодорхойлсон журам;

6.11. Хувийн хөрөнгө оруулалтын сангуудыг нийлүүлэх тухай шийдвэр, журам, гэрээг сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцож байгаа нэгж эрх эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар батална.

6.12. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар тухайн шинээр үүсгэн байгуулагдах хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрмийг тогтоох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар бол тухайн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоно.

6.13. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрх нь энэ журмын 6.10.4-т заасан хөрвөсөн саналын эрхтэй тэнцүү байна.

6.14. Тухайн өөрчлөн байгуулагдаж буй хувийн хөрөнгө оруулалтын сангуудийн сангийн менежер нь Хороонд энэхүү журмын 6.10.1-6.10.4-т заасан баримт бичгийг хүргүүлнэ.

6.15. Хороо уг баримт бичгийг хүлээн авч тухайн өөрчлөн байгуулагдаж буй хувийн хөрөнгө оруулалтын сангуудын тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлнэ.

Долоо. Гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын санг Хороонд бүртгүүлэх

7.1. Гадаад улсад бүртгэлтэй хувийн хөрөнгө оруулалтын сан нь Хороонд бүртгүүлсний үндсэн дээр Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 43.1-т заасан хязгаарын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж болно.

7.2. Гадаад улсад бүртгэлтэй хувийн хөрөнгө оруулалтын санг Хороонд бүртгүүлэхэд дараахь шаардлагыг тавина:

7.2.1. хуулиар шаардсан бол өөрийн улсын санхүүгийн зах зээлийг зохицуулагч эрх бүхий төрийн байгуулагаас хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх;

7.2.2. Монгол Улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай санхүүгийн чадавхитай байх;

7.2.3. эрх бүхий кастодиантай гэрээ байгуулсан байх;

7.2.4. эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд байх;

7.2.5. хөрөнгө оруулалтын сангийн хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоосон мэдээллийг тухай бүр Хороонд болон хөрөнгө оруулагчдад өгч ажиллах.

7.3. Гадаад улсад бүртгэлтэй хувийн хөрөнгө оруулалтын санг бүртгүүлэх хүсэлтэд дараахь баримт бичгийг хавсаргасан байна:

7.3.1. тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой мэдээлэл, тухай улсаас олгосон гэрчилгээний хуулбар;

7.3.2. хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон тухай өөрийн улсын эрх бүхий төрийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

7.3.3. кастодиан, менежментийн компани, менежер нь үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий болохыг нотлох хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн, эсхүл зөвшөөрлийн, гэрчилгээний хуулбар;

7.3.4. тухайн хувийн хөрөнгө оруулалтын сан нь Монгол улсад үйл ажиллагаа эрхлэхэд татгалзах зүйлгүй болох тухай эрх бүхий өөрийн улсын зохицуулах байгууллагаас авсан тодорхойлолт, тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн эрх барих байгууллагын шийдвэрийн хуулбар;

7.3.5. тухайн хувийн хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлж байгаа, удирдлагыг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээд, албан тушаалтны тодорхойлолт;

7.3.6. хамгийн сүүлийн улирлын болон өмнөх жилийн эцсийн санхүүгийн аудиторoor баталгаажуулсан тайлангийн хувь.

7.4. Хороо материал нь бүрдсэн хүсэлтийг хүлээн авснаас ажлын 30 хоногийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

7.5. Хороо бүртгэхээр шийдвэрлэсэн бол уг шийдвэрт үйл ажиллагаа эрхлэх хүрээ, үйл ажиллагаандаа мөрдөх нөхцөл, шаардлага зэргийг тусгана.

7.6. Гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сан нь Хорооны бичгээр өгсөн хариуг хүлээн авсан өдрөөс үйл ажиллагаагаа Монгол Улсад эрхлэх эрх нээгдэнэ.

Найм. Хувийн хөрөнгө оруулалтын санг татан буулгах

8.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 30.1-д заасан дараах тохиолдолд хувийн хөрөнгө оруулалтын санг татан буулгана:

8.1.1. хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа дуусгавар болсон;

8.1.2. хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас тухайн санг сайн дурын үндсэн дээр хугацаанаас өмнө татан буулгахаар шийдвэрлэсэн;

8.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компани хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулсан бөгөөд сангийн нэгж эрх эзэмшигчдийн дийлэнх олонх санг татан буулгахаар шийдвэр гаргасан;

8.1.4. онцгой нөхцөл байдал үүссэн бөгөөд албадан татан буулгах шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

8.1.5. хувийн хөрөнгө оруулалтын сан дампуурсан;

8.1.6. хуульд заасан бусад;

8.2. Хувийн хөрөнгө оруулалтын санг татан буулгах шийдвэрийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 30.2-т заасан дараах этгээд гаргана.

8.2.1. энэ журмын 8.1.1-8.1.3-т заасан үндэслэлээр хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал;

8.2.2. энэ журмын 8.1.4, 8.1.5-д заасан үндэслэлээр Хороо болон эрх бүхий бусад этгээдийн хүсэлтийг үндэслэн шүүх;

8.2.3. журамд заасан эрх бүхий бусад этгээд;

8.3. Хувийн хөрөнгө оруулалтын сан болон сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх, түүнд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх болон хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлэх үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг төрийн байгууллагын зүгээс тухайн сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өгөх баталгаа гэж үзэхгүй бөгөөд хөрөнгө оруулалтын сан, түүнд үйлчилгээ үзүүлж байгаа зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны улмаас хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдэд болон бусдад учирсан хохирлыг төр хариуцахгүй.

8.4. Хувийн хөрөнгө оруулалтын сан өөрийн санаачлагаар татан буугдах тохиолдолд татан буулгах ажиллагааг дараах журмын дагуу гүйцэтгэнэ:

8.4.1. тухайн хөрөнгө оруулалтын сангийн менежер нь хувийн хөрөнгө оруулалтын санг татан буулгах журмын төслийг боловсруулж, сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн татан буулгах шийдвэрийн хамт батлуулна;

8.4.2. Хороонд татан буулгах журам болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас гарсан татан буулгах тухай шийдвэрийг холбогдох бичиг баримтын хамтаар хүргүүлнэ;

8.4.3. Хороо тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн татан буулгахтай холбоотой материалыг шалгаж татан буулгах ажиллагааг үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн сангийн татан буулгахад хяналт тавих үүрэгтэй эрх хүлээн авагчийг томилно.

8.4.4. татан буулгах Хорооны зөвшөөрлийг авсан хувийн хөрөнгө оруулалтын сан нь татан буулгах журмыг нэгж эрх эзэмшигчдэд хүргүүлэн, өөрийн мэдээллийн хэрэгслээр нийтэд ажлын 2 өдрийн дотор мэдээлнэ;

8.4.5. кастодианы үйл ажиллагааг зогсоон, хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдэд хөрөнгийг аюулгүй байлгах баталгааг хангаж, хөрөнгийг худалдахаас бусад захиран зарцуулахыг хориглоно;

8.4.6. хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг худалдан борлуулах, сангаас авлагатай этгээдийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах, сангийн бусад төлбөр тооцоог дуусгавар болгох, санг татан буулгахтай холбоотой харилцааны зардлыг сангийн хөрөнгөөс тухайн сангийн менежер гарган авах бөгөөд үлдсэн мөнгөн хөрөнгийг сангийн нэгж эрх эзэмшигчдийн нийлүүлсэн нэгж эрхийн дүнд нь хувь тэнцүүлэн хуваарилна;

8.4.7. хувийн хөрөнгө оруулалтын сангаас авлагатай этгээдээс нэхэмжлэлийг хүлээн авах хугацаа нь энэ талаар нийтэд мэдээлсэн өдрөөс 6 сарын дотор байна.

8.4.8. хувийн хөрөнгө оруулалтын сангаас авлагатай этгээдээс нэхэмжлэл хүлээн авах хугацаа дууссаны дараа татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээд нь сангийн нийт хөрөнгө болон төлөхөөр хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг тусгасан санхүүгийн тайлан гаргаж Хороонд хүргүүлэх ба татан буулгах ажиллагааг менежментийн компани гүйцэтгэж байгаа бол дээрх санхүүгийн тайланг кастодианаар хянуулсан байна;

8.4.9. хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах явцад уг санд төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн нийт дүн нь итгэмжлэн удирдах журмаар тогтоосон хэмжээнд хүрээгүйгээс татан буулгаж байгаа бол татан буулгах ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээд нь санд төвлөрсөн хөрөнгийг худалдан борлуулж, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан дарааллын дагуу тооцоо хийх бөгөөд санд төвлөрүүлэхээр тогтоосон хугацаа дууссанаас хойш хоёр долоо хоногийн хугацаанд багтаан тооцоог дуусгана;

8.4.10. Хорооны томилсон эрх хүлээн авагч байцаагч тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн татан буулгалтын тайланг хянаж үзээд, аль нэгэн этгээдийн эрх ашиг хохироогүй гэж үзээд тухайн хөрөнгө оруулалтын санг татан буулгасан шийдвэр гаргана;

8.4.11. Хорооноос татан буугдсан гэж үзсэн шийдвэр гармагц, санг улсын бүртгэлээс хасуулан тухайн хөрөнгө оруулалтын сан татан буугдсанд тооцно;

8.4.12. хувийн хөрөнгө оруулалтын санг энэхүү журмын 8.1.1-8.1.3-т заасан үндэслэлээр татан буулгах ажиллагааг хууль тогтоомж, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн хүрээнд Хороо гүйцэтгэнэ.

Ес. Хариуцлага

9.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хорооны хянан шалгагч улсын байцаагч ноогдуулна.

9.2. Энэ журмыг зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын хэмжээ нь эрүүгийн хэрэг үүсгэхээр бол Гэмт хэргийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу холбогдох хууль сахиулах байгууллагад шилжүүлнэ.

9.3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн этгээдэд энэ журмаар хариуцлага ноогдуулахгүй.

9.4. Энэ журмын 9.1-т заасан хариуцлага хүлээсэн нь тухайн этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

ooOoo